

Төслийн нэр, дугаар			Төсөл хэрэгжүүлэгч болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн зорилго	Төслийн үндэслэл, хэлбэр	Төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, үр дүн, тайлан	Гүйцэтгэлийн хувь
Төслийн нэр /Монгол/	Төслийн нэр /Англи/	Төслийн дугаар					
Эрүүл мэндийн үндэсний тооцооны эрх зүйн орчинг шинэчлэх, 2016-2021 оны үр дүнг тооцон тайлагнах ажил	legal environment of national health accounts and results reporting for 2016-2021	2023/1348411-0	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Эрүүл мэндийн үндэсний тооцооны эрх зүйн орчинг шинэчлэх, 2016-2021 оны үр дүнг тооцон тайлагнах	ЭМҮТ-ны эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, тогтвортой санхүүгийн эх үүсвэр хангалтгүй, холбогдох мэдээллийн урсгал, маягт, ЭМҮТ-ны шинэчилсэн ангилал одоог хүртэл батлагдаагүй, тухайн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн болон ажлын залгамж холбоо алдагдсан, олон улсын аргачлалын мэдлэг мэдээлэл дутмаг байдал, сургалтын гарын авлага, КОВИД-19 цар тахал зэрэг олон шалтгааны улмаас эрүүл мэндийн үндэсний тооцоог тооцон гаргах ажил удааширч, зогссон. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2011 оноос эрүүл мэндийн үндэсний тооцооны шинэчилсэн, өргөтгөсөн SHA2011 (System of health account 2011) ангиллыг гаргаж ашиглаж эхэлсэн.	Шинэчилсэн аргачлалаар ангиллыг 18 болгон өргөтгөж, тухайн улс орны онцлогт нийцүүлэн тэдгээрээс авч ашиглахыг зөвлөсөн. Зөвлөмжийн дагуу Монгол улсын эрүүл мэндийн үндэсний тооцооны ангиллыг 2003 онд батлагдсан үндсэн 3 ангиллыг SHA2011 аргачлалд нийцүүлэн шинэчлэх шаардлага үүсч байна. Үүний дагуу Монголд улсад ашиглах боломжтой 11 ангиллыг орчуулан тушаалд өөрчлөлт оруулах талаар танилцуулсан. 2016-2021 оны Эрүүл мэндийн үндэсний тооцооллыг “Эрүүл мэндийн тооцооны систем-2011” стандартын дагуу 3 үндсэн бүлэг, олон улсад харьцуулах 23 үзүүлэлт, хэмжээс хоорондын хамаарлыг харуулах 30 хавсралт хүснэгттэйгээр нэгдсэн тооцоолол, үр дүнгийн тайланг боловсруулан дүн шинжилгээ хийсэн. Тооцооллын үр дүнг ЭМЯ-ны “Эрүүл мэндийн үндэсний тооцооны зохицуулах зөвлөл”-д 2023 оны 1127 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	100%
Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг хүн ам, өвчлөл, тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй уялдуулан судлах судалгаа	Human Resource needs assessment of local health facilities	2023/1362976-0	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Хүний нөөцийн хэрэгцээг орон нутгийн хүн амын өвчлөл, тоног төхөөрөмжийн байдалтай харьцуулан судлах	Хүн амын өвчлөл, нас баралтын үндсэн шалтгаанд ниглэсэн тусламж үйлчилгээг хүн бүр хүртээмжтэйгээр авах боломжоор хангагдсан эсэхийг тодруулахын тулд эрүүл мэндийн хэрэгцээнд суурилсан хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангалтад тулгуурлан судлахыг зорьж байгаа юм. Энэхүү судалгаа хийгдсэнээр хүн бүр эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг хэрэгцээтэй үедээ, хаана амьдарч байгаагаас үл хамааран санхүүгийн хүндрэлгүйгээр авах боломжийг бүрдүүлэхэд бодлого, шийдвэр гаргагч нарыг нотолгоот мэдээллээр хангаж, бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг хангасан төлөвлөлт хийхэд чухал судалгаа болох юм.	Батлагдсан аргачлал, удирдамжийн дагуу баримтын судалгааг 21 аймагт, бүсчилсэн түүвэрээр агшингийн судалгааг 10 аймагт томилолтоор очин судалгааг хийсэн. Монгол улсын 2022 оны эрүүл мэндийн үзүүлэлтээс хүн амын өвчлөлийг бүс нутгаар харахад амьсгал, хоол боловсруулах, зүрх-судасны тогтолцооны өвчлөл болох дотрын өвчин ижил түвшинд тэргүүлж байна. Тэргүүлж буй өвчлөлийг эрэлт, тухайн тусламж үйлчилгээг үзүүлэх нөөцийг хэрэгцээ гэж үзвэл 2022 оны байдлаар улсын хэмжээнд дотрын эмч 1335 (100%) үүнээс Сумын эрүүл мэндийн төвд 69 (5,1%), АНЭ-т 131(9,8%), БОЭТ-д 61 (4,5%) нь ажиллаж байна. ДЭМБ-ын зөвлөснөөр тусламж үйлчилгээ үзүүлэхэд тохиромжтой эмчийн тоо 1000 хүн амд 2,5 гэж үздэг бол БОЭТ, АНЭ-д дотрын эмчийн тоог өвчлөлийн тоо баримттай харьцуулахад хангалтгүй буюу дунджаар 5,5 эмч хэрэгцээтэй байна. БОЭТ, АНЭ-д бүтэц үйл ажиллагааны стандарт болон батлагдсан орон тоотой хүний нөөцийг харьцуулахад хангалттай боловч өвчлөлтэй харьцуулахад хангалтгүй, төрөлжсөн мэргэжлийн эмч (0-3) дутагдалтай байна. Сумын эрүүл мэндийн төвийн нийт эмч нарын 67-80% нь мэргэшсэн дотрын эмчгүй ерөнхий мэргэжлийн эмч нар ажиллаж байна.	100%
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ болон ажлын байрны сургалтын удирдамж	Terms of reference on conducting on-site training of health professionals monitoring and evaluation of health organizations regading health service quality and patient safety	409	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үндэсний сургагч багшийн тусламжтайгаар ажлын байрны сургалт зохион байгуулж, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх замаар тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зүгээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд онцгүй анхаарал хандуулж тусламж үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчид учирч болох хохирол эрсдэлийг 2030 он хүртэл шат дараатайгаар бууруулах	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үндэсний сургагч багшийн тусламжтайгаар ажлын байрны сургалт зохион байгуулж, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаарх мэдлэг жур чадварыг нэмэгдүүлэх замаар тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх сургалтыг Сүхбаатар, Дорноговь, Говь-Сүбэр аймгуудад амжилттай зохион байгуулсан.	100%
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэх, мэдээлэх, суралцах, хариу арга хэмжээ авах ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, хэлэлцүүлэг, програм хангамжийн ажиллагааг дэмжих удирдамж	Training guidelines for recording reporting learning response and capacity building incidents and risk related to health care and services	48	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Эрүүл мэндийн байгууллагуудад тохиолдол, эрсдэлийг бүртгэх програм хангамжийг нэтрүүлж, хэрэглээг хэвшүүлэх. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд учирч болох тохиолдол, эрсдэлийг илрүүлэх бууруулах чиглэлээр төлөвлөх хэрэгжүүлэх хүрээнд мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/136 дугаар тушаалаар 2022-2025 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр хийх ажлын удирдамж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг албагуулсан билээ. Уг төлөвлөгөөний 3.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол мэдээлэх, суралцах тогтолцоог сайжруулах 3.2.2 Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээтэй холбоотой аюулгүй байдал алдагдсан тохиолдлыг давтан гаргахгүй байх, түүнээс суралцах орчин бий болгох чиглэлээр эрүүл мэндийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх үүрэг болгосон. Түүнчлэн ДЭМБ-ийн санхүүжилтээр ЭМС-н А/566 тушаалын хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэх программ хангамж хийгдсэн тул эрүүл мэндийн байгууллагуудад программыг нэвтрүүлэх сургалт зохион байгуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.	Эрүүл мэндийн байгууллагуудад тохиолдол, эрсдэл бүртгэх үйл явцдаа цаасан бүртгэл ашигилдаг байсан бол програм хангамжийг нэвтрүүлснээр компьютер болон гар утаснаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд учирч болох тохиолдол эрсдэлийг бүртгэж хэвшинэ.	100%